

БОГИНО ХУГАЦААНЫ СУРАЛЦАХ (D 2 8)

ОЛГОХ ХҮРЭЭ:

Их дээд, сургууль хоорондын хэлэлцээрийн дагуу оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдах гэж буй оюутан.

Монгол Улсаас БНСУ-д суралцахаар төлөвлөж буй иргэн **Солонгосын Виз Мэдүүлэх Төвөөр** дамжуулан визээ мэдүүлнэ. Та 2 жил хүртэлх хугацаатай нэг удаагийн нэвтрэх эрхтэй виз мэдүүлж болох бөгөөд БНСУ-ын ЭСЯ-аас нэмэлт бичиг баримтууд шаардаж болно. Виз мэдүүлж буй МУ-ын иргэн хамгийн сүүлд төгссөн сургуулийн диплом ба дүнгийн жагсаалтын эх хувийг СВМТ-д өгөх бөгөөд эцсийн шийдвэр гарсан даруйд паспортын хамт буцаан олгогдоно.

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТУУД

1. Виз мэдүүлгийн маягт (Маягт 17): Цээж зураг (3.5 x 4.5 см хэмжээтэй, сүүлийн 6 сарын дотор авахуулсан) визний хураамж 60 ам.доллар
2. Гадаад паспорт, хуулбарын хамт 1 хувь (Виз мэдүүлж буй өдрөөс хойш хамгийн багадаа 6 сарын хүчинтэй байх)
3. Элсэлтийн зөвшөөрлийн гэрчилгээ, Сургуулийн ААН гэрчилгээний хуулбар
4. Харъяа сургуулийн тодорхойлолт болон оюутны дүнгийн тодорхойлолт
5. **Солонгосд амьдрах зардалыг батлан даах**
 - Батлан даагч 1, 2:
 - Батлан даагчийн иргэний үнэмлэхийн хуулбар болон төрөл садангийн лавалгаа
 - Гадаадад суралцах зардлын даана гэсэн гар өргөдөл, ажлын газрын тодорхойлолт
 - Батлан даагчийн сарын орлогыг нотлох бичиг баримт (Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар болон лавлагаа, татварын тодорхойлолт г.м)
6. Гэрлэлтийн лавлагаа (сүүлийн 45 хоногт олгогдсон байх)
19 нас хүрээгүй иргэний хувьд төрсний бүртгэлийн лавлагаа авах бөгөөд төрсний бүртгэлийн лавлагаа дээр эцэг цэхийн төрсөн он сар өдөр тэмдэглэгдээгүй тохиолдолд эцэг эхийн иргэний үнэмлэхний хуулбар авчрах.
Гэрлэлтээ батлуулаагүй хүүхэдтэй иргэний хувьд хүүхдийн төрсний бүртгэлийн лавлагаа нэмэлтээр авах.
7. Цагдаагийн газрын тодорхойлолт (Анх удаа виз мэдүүлж байгаа тохиолдолд, Сүүлийн 45 хоногт олгогдсон байх)
8. Сүрьеэгийн шинжилгээ: (БНСУ-ын ЭСЯ-аас зөвшөөрөгдсөн эмнэлгээс авсан байх)